



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 622

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймаг Ханх дахь гаалийн хорооны хөрөнгөд бүртгэлтэй нийт 8,374,600.00 (найман сая гурван зуун далан дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Хил хамгаалах ерөнхий газрын хилийн 0257 дугаар ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймаг Ханх дахь гаалийн хорооны дарга Ч.Саранхүү, Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн 0257 дугаар ангийн захирагч хурандаа Б.Батбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001307



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
682 дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймаг Ханх дахь гаалийн хорооны балансаас Хил хамгаалах ерөнхий газрын
харьяа Хилийн 0257 дугаар ангийн балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Шинэчлэн тогтоох үнэ	Цаашид ашиглах жил
1	ЗИЛ-131 маркийн, 39-12 ХӨВ улсын дугаартай, арлын дугаар-422257	10/10/2010	ш	1	5,200,000.00	5,200,000.00	5,200,000.00	3,000,000.00	2
2	Бага оврын трактор, 84-44 УБ улсын дугаартай, арлын дугаар-L7520001070801887	12/19/2007	ш	1	3,174,600.00	3,174,600.00	3,174,600.00	1,000,000.00	2
				2		8,374,600.00	8,374,600.00	4,000,000.00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			2 (хоёр)		8,374,600.00 (найман сая гурван зуун далан дөрвөн мянга зургаан зуун)	8,374,600.00 (найман сая гурван зуун далан дөрвөн мянга зургаан зуун)	4,000,000.00 (дөрвөн сая)	